



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/9

Улаанбаатар хот


Хүн амын амьжиргааны 2015 оны  
доод түвшинг тогтоох тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, "Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Хүн амын амьжиргааны доод түвшин"-ий 2015 онд мөрдөх хэмжээг хавсралтаар баталж, 2015 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.


Хоёр. Шинэчлэн баталсан "Хүн амын амьжиргааны доод түвшин"-г холбогдох байгууллагад албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлэхийг Төрийн захиргаа, удирдлагын газар /Т.Гантөмөр/-т даалгасугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

Үндэсний статистикийн хорооны даргын  
2015 оны 1 дүгээр сарын 29 -ний өдрийн  
А/9 тоот тушаалын хавсралт



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	164 200
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	167 200
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	164 300
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	160 800
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	185 400